



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
А.ДОРЖСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/20

Маңдалговь

**Аймгийн аварга шалгаруулах сонирхогчдын
дугуйн тэмцээнд зардал гаргах тухай**

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2021 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан Аймгийн аварга шалгаруулах сонирхогчдын дугуйн тэмцээний төсвийг нэгдүгээр хавсралтаар, шүүгч нарын нэрсийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тэмцээний зардалд шаардагдах 40,200 (Дөчин мянга хоёр зуу) төгрөгийг тэмцээн уралдааны зардлаас гаргахыг ерөнхий нягтлан бодогч (Б.Мөнхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



А.ОТГОНБААТАР